

АНУ дахь Монголчуудын Ширээний Теннисний Аварга Шалгаргуулах Тэмцээний Дүрэм

Энэхүү дүрэм нь АНУ дахь Монголчуудын Ширээний Теннисний Аварга Шалгаргуулах Тэмцээний үндсэн зорилго, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг зохион байгуулах дүрэм заалтуудыг батлан гаргасан баримт бичиг мөн. АНУ дахь Монголчуудын Ширээний Теннисний Аварга Шалгаргуулах Тэмцээн нь Монгол Улсын Ширээний Теннисний Холбооны жилийн хөтөлбөрт тусгагдсан “ОРОН НУТГИЙН ЧАНАРТАЙ” зэрэглэлтэй тэмцээн болно.

Нэг, Тэмцээний зорилго:

АНУ-д амьдардаг Монголчуудын дунд ширээний теннисний спортыг сонирхон хичээллэхэд нь түлхэц болох, ширээний теннисийн спортыг дэлгэрүүлэн сурталчлахад тэмцээний зорилго оршино.

Хоёр, Тэмцээн явагдах газар, огноо:

АНУ дахь Монголчуудын Ширээний Теннисний Аварга Шалгаргуулах Тэмцээн (АМШТАШТ) жил бүр явагдана. Тэмцээнийг Зохион Байгуулах Хороо нь Америкийн Монголчуудын Ширээний Теннисний Холбоотой (МАТТА-Mongolian American Table Tennis Association) харилцан тохиролцсоны үндсэн дээр тэмцээний зарыг тэмцээн болохоос 2 сарын өмнө зарлана.

Гурав, Бүтэц , Удирдлага:

3.1 АМШТАШТ ийг тухайн жилийн тэмцээн зохион байгуулж буй хотын Зохион Байгуулах Хороотой (ЗБХ) МАТТА хамтарч зохион байгуулна. МАТТА нь тэмцээн батлагдсан дүрмийн дагуу явагдаж буйд хяналт тавих үүрэгтэй. ЗБХ нь энэхүү батлагдсан дүрмийн дагуу зохион байгуулах үүрэгтэй.

3.2 МАТТА ийн Тэргүүлэгчид нь Ерөнхийлөгч , Дэд Ерөнхийлөгч, Нарийн Бичгийн Дарга, тэргүүлэгч гишүүдээс бүрдэнэ. МАТТА ийн Ерөнхийлөгчийг АНУ дахь Монголчуудын Ширээний Теннисийн Аварга Шалгаргуулах Тэмцээнийн үеэр нийт тамрчдын олонхийн санлаар сонгоно. МАТТА ийн Ерөнхийлөгчийн сонгууль хоёр жил тутам явагдана. МАТТА ийн Дэд Ерөнхийлөгчөөр тухайн жилийн тэмцээнийг зохион байгуулж буй хотын ЗБХ ны Тэргүүнийг сонгоно. МАТТА ийн Нарийн Бичгийн Дарга, Тэргүүлэгч гишүүдийг Ерөнхийлөгч нь эрэгтэй эмэгтэй тамирчдын болон хотууддын төлөөлөл, ажлын манлайлал гэх мэт шалгууруудыг харгалзан сонгож томилно. Түүнчлэн МАТТА ийн Ерөнхийлөгч шаардлагатай гэж үзвэл МАТТА ийн үйл ажиллагаатай холбоотой санхүү, сурталчилгаа, дүрмийн, сургалтын гэх мэт үүрэгтэй тэргүүлэгч гишүүдийг сонгон томилж болно. МАТТА ийн тэргүүлэгчдийн хурлаар дүрэмд өөрчлөлт оруулах, үйл ажиллагааны ерөнхий чиглэл өгөх, байгууллага хувь хүмүүстэй хамтран ажиллах, санхүүгийн шийдвэр

гаргах эрхтэй.

Дөрөв, Тэмцээний ангилал:

4.1 Тэмцээн нь Сонирхогчид – Recreational level (Эрэгтэй, Эмэгтэй) , Ахисан-Advanced level (Эрэгтэй, Эмэгтэй) , Багийнн-Team (Эрэгтэй 2, Эмэгтэй 2) , Хос-Mixed Double (Эрэгтэй, Эмэгтэй) тоглолтууд гэсэн ангиллаар явагдана. МАТТА нь АМШТАШТ д оролцогчдын тоо, ЗБХ ны боломж, тамирчдын түвшин зэргийг харгалзан тэмцээнийг илүү сонирхолтой болгох үүднээс тэмцээний ангиллуудыг нэмж болно. Үлгэрбэл Сонирхогчид – Recreational level (Эрэгтэй, Эмэгтэй) , Дунд түвшин – Intermediate level (Эрэгтэй, Эмэгтэй) Ахисан-Advanced level (Эрэгтэй, Эмэгтэй) , Мастер – Masters level (Эрэгтэй, Эмэгтэй) , Багийн-Team (Эрэгтэй 2, Эмэгтэй 2) , Хос-Mixed Double (Эрэгтэй, Эмэгтэй) , Хос-Double (Эрэгтэй хос, Эмэгтэй хос), Хүүхдүүд- Children, Идэр нас-Junior гэх мэт

4.2 АМШТАШТ нд насны дээд доод хязгаар байхгүй. 18 аас доош насны тамирчид нь хууль ёсны хариуцагчаас тэмцээнд оролцох зөвшөөрөл авсан байна. Зөвшөөрлийг тухай хотоос ирж буй багийн ахлагч хариуцаж авна.

Тав, Тэмцээнд оролцох эрхтэй тамирчид:

5.1 АМШТАШТ оролцож байгаа тамирчид нь өмнөх жилийн тэмцээнээс дараа жилийн тэмцээний хооронд АНУ-д “3” ба түүнээс дээш сар амьдарсан Монголчууд оролцох эрхтэй. Шалгах үндсэн бичиг баримт паспорт болно. АНУ-д 3 түүнээс доош хугацаагаар зорчиж буй тамирчдыг МАТТА ын зөвшөөрөлгүйгээр оролцохыг хориглоно.

5.2 Тухайн жилийн тэмцээн зохион байгуулж буй хотын ЗБХ нь МАТТА тай зөвшилцсэний үндсэн дээр ЗБХ ны урилгаар Монгол Улсаас Монголын Ширээний Теннисийн өндөр зэрэглэлтэй тамирчдыг урьж оролцуулж болно. Зорилго нь АНУ-д амьдардаг тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, туршлагаа хуваалцах, ширээний теннисний спортыг дэлгэрүүлэн сурталчлахад оршино.

Зургаа, Тэмцээний зохион байгуулалт:

6.1 ЗБХ нь техникийн зөвлөлгөө, тэмцээн болох газар, заал, холбогдох үйлчилгээ, ерөнхий шүүгчийг бүрдүүлэх, анхан шатны тусламж, нээлтийн арга хэмжээ, хаалтын үдэшлэг, шагнал урамшуулал, бусад холбогдох ажлуудыг удирдан зохион байгуулна.

6.1 АМШТАШТ ийг МАТТА , ЗБХ оос томлигдсон Ерөнхий Шүүгч (ЕШ) удирдан зохион байгуулна. Ерөнхий Шүүгчээр боломжтой бол албан ёсны шүүгчээр, эсвэл туршлагатай мастераар Ерөнхий Шүүгчээр томилоно.

6.2 ЕШ нь Монгол Ширээний Теннисний Холбооны мөрдлөгө болдог Олон Улсын Ширээний Теннисний Холбооны дүрмийн дагуу тоглолтыг шүүнэ. ЕШ тоглолт бүр дээр оноо бүртгэгчдийг ажлуулах үүрэгтэй.

6.3 Тэмцээнд оролцож буй тамирчид нь тэмцээнд оролцох мэдүүлэгээ батлагдсан маягтын дагуу бөглөж ЗБХ оос зохион байгуулж буй техникийн зөвлөлгөөнд оролцохдоо хураамжийн хамт бүрдүүлж өгнө. Хураамжийг МАТТА, ЗБХ шийдвэрлэн тогтооно.

6.4 Техникийн зөвлөлийн хурлыг МАТТА ийн гишүүд, ЗБХ гишүүд, Ерөнхий Шүүгчид зохион байгуулана. Техникийн зөвлөлийн хуралд АМШТАШТ д оролцож буй тамирчид оролцоно. Тодорхой шалтгаанаар ирэх боломжгүй тамирчид байвал урьдчилан ЗБХ той холбогдож мэдэгдэнэ.

6.5 ЗБХ нь мэдүүлэг, хураамжаа бүрдүүлээгүй тамирдыг тэмцээнээс хасах эрхтэй. Тэмцээний дундуур шинэ тамирчдыг нэмж оруулахыг хориглоно.

6.6 ЕШ болон ЗБХ ноос баталсан хуваарийн дагуу тоглолт явагдах бөгөөд зарлагдсан хуваарьт цагтаа 15 минутын дотор тоглолтын талбайд гараагүй тамирчдыг ЕШ хожигдсонд тооцох эрхтэй.

6.11 Тэмцээний хэсэг тэргүүлэх тамирчныг өмнөх жилийн үзүүлсэн амжилтаар тодорхойлж бүртгэнэ. (Өмнөх жилд тэргүүн байрууд эзэлсэн тамирчид хэсгүүдийг тэргүүлнэ) Үлдсэн тамирчид сугалаагаар хэсгээ сонгоно. Боломтой бол нэг хотоос оролцож буй тамирчдыг нэг хэсэгт бүртгэхгүй байхыг баримтлана.

6.12 Багийн-Team ангилалд тэмцээнийг өрсөлдөөнтэй, сонирхолтой болгох үүднээс өмнөх болон тухайн жилийн Ахисан-Advanced Level д тоглосон тамирчид багийн тоглолтын багийн ахлагчаар сонгогдож хоёр дахь гишүүн өмнөх жилийн Ахисан-Advanced Level тоглолтод амжилттай оролцоогүй тамирчид эсвэл Сонирхогчид-Recreational level д эхний дөрвөн байрууд эзэлсэн зэрэг амжилтуудыг харгалзан үзэж сонгоно. Үлдсэн хоёр гишүүд нь өмнөх жилийн тоглолтод амжилт гаргаагүй тамирчдаас бүрдүүлнэ. Баг нь таван гишүүнтэй байж болох ба тоглолтын үндсэн хоёр эрэгтэй хоёр эмэгтэй тамирчдаас бүрдэнэ. Багийн тоглолт урьдчилан сугалгаа хийж хүйс хүйсээр тоглоно.

6.13 Тэмцээнийг өрсөлдөөнтэй, сонирхолтой болгох үүднээс Хос-Mixed Double (Эрэгтэй, Эмэгтэй) ангилалд Ахисан-Advanced Level, Сонирхогчид-Recreational level ангилалуудад эхний дөрвөн байр эзэлсэн тамирчид хос болохыг хориглоно. Мөн Ахисан-Advanced Level ийн тамирчид хос болохыг хориглоно.

6.14 Эрэгтэй Сонирхогчид-Recreational level ангилалд түрүүлсэн тамирчин дараа жилийн тэмцээнд Ахисан-Advanced Level ангилалд тоглоно. Хэрэв хүсвэл эрэгтэй Сонирхогчид-Recreational level ангилалд амжилттай оролцсон тамирчид дараагийн жилийн тэмцээнд Ахисан-Advanced Level ангилалд оролцож болно. Түүнчлэн хэрэв хүсвэл Эмэгтэй Сонирхогчид-Recreational level ангилалд амжилттай оролцсон тамирчид дараагийн жилийн тэмцээнд Эрэгтэй Сонирхогчид-Recreational Level ангилалд оролцож болно.

6.15 МАТТА, ЗБХ тэмцээний ганцаарчилсан ангилалын тоглолт дуусаны дараа Багийн-Team ангилалд, Хос-Mixed Double (Эрэгтэй, Эмэгтэй) ангилалд амжилттай оролцсон тамирчдыг зарлаж дүрмийн 6.14 заасан зүйлийг үндэслэн Багийн-Team

ангилалд, Хос-Mixed Double ангилалд оролцох тамирчдыг бүртгэнэ.

Долоо, Шагнал урамшуулал:

7.1 Тэмцээний ганцаарчилсан, багийн ангилалд тус бүрт түрүүлсэн тамирчид, багт Аваргын Цом, Алтан медаль, диплом, мөнгөн шагнал ба II, III байрт эзэлсэн багт Мөнгө, Хүрэл медаль, диплом, мөнгөн шагнал олгоно. Хос тоглолтод эхний I, II, III байрт эзэлсэн багт Алт, Мөнгө, Хүрэл медаль, диплом, мөнгөн шагнал олгоно.

Найм, Бусад:

8.1 Тэмцээнд оролцож буй бүх баг, тамирчид нь харилцан ойлголцож бие биеэ хүндэтгэн эв нэгдэлтэй шударгаар өрсөлдөх ёстой. Хэрэв шаардлагатай гэж үзвэл МАТТА, ЗХБ, ЕШ нар хуралдаж ёс зүй алдаа гаргасан гэж үзвэл баг, тамирчдыг тэмцээнээс хасах эрхтэй. ЗБХ энэхүү заалтыг тэмцээнд оролцож буй баг, тамирчдад танилцуулах үүрэгтэй.

8.2 АНУ дахь Монголчуудын Ширээний Теннисний Аварга Шалгаргуулах Тэмцээн нь өөрийн онцлох тэмдэг, шилжин явах тугтай байж болно. ЗБХ нь тэмцээний статистик бүртгэлийг хөтлөж МАТТА д бүрдүүлж өгнө. МАТТА нь тэмцээнд амжилттай оролцсон тамирчдын спортын цол, зэргийг Монгол Ширээний Теннисний Холбооны дүрмийн дагуу Монгол Ширээний Теннисний Холбоонд мэдүүлж олгуулах ажлыг хариуцана.

8.3 МАТТА, ЗБХ ний үйл ажиллагаа, шийдвэрийг үл хүндэтгэх тохиолдолд баг, тамирчдыг тэмцээнээс хасах эрхтэй.

8.5 ЗБХ нь тэмцээний аюулгүй үйл ажиллагааг хангаж ажиллах үүрэгтэй. Дотоод дэг журам, заавал мэдэх, дагаж мөрдөх санамжуудыг баг тамирчид, хөгжөөн дэмчигчдэд урьдчилан танилцуулна. Тэмцээний үеээр урьдчилан төлөвлөх, мэдэх бололцоогүй асуудлууд гарсан тохиолдолд ЗБХ шийдвэр гаргана.

8.6 МАТТА, ЗБХ нь тэмцээнийг зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой даатгалын харицлага хүлээхгүй болно.

8.7 ЗБХ нь АНУ дахь Монголчуудын Ширээний Теннисний Аварга Шалгаргуулах Тэмцээнтэй холбоотой зохион байгуулалтын болон дүрмийн өөрчлөлт хийх шаардлага гарвал тэмцээн болохоос гурав сарын өмнө МАТТА ийн Тэргүүлэгчдэд мэдэгдээд шийдвэр гаргуулна.

Америкийн Монголчуудын Ширээний Теннисний Холбоо
(МАТТА-Mongolian American Table Tennis Association)

зохион байгуулалтын бүтэц

ЕРӨНХИЙЛӨГЧ

АНУ дахь Монголчуудын Ширээний Теннисийн Аварга Шалгаргуулах Тэмцээнийн үеэр нийт тамирчдын олонхийн санлаар сонгоно

ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ

Тухайн жилийн тэмцээнийг зохион байгуулж буй хотын ЗБХ ны Тэргүүнийг сонгоно

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ерөнхийлөгч томилно

ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮД

Ерөнхийлөгч томилно

- Хотуудын тэргүүлэгчид (эрэгтэй эмэгтэй)
- Дүрэм, хяналт хариуцсан тэргүүлэгч
- Сургалт хариуцсан тэргүүлэгч
- Санхүү хариуцсан тэргүүлэгч
- Сурталчилгаа хариуцсан тэргүүлэгч

АНУ дахь Монголчуудын Ширээний Теннисний Аварга
Шалгаргуулах Тэмцээний Мэдүүлэг

Огноо:

Хотын төлөөлөл

Тамирчны нэр:

Спортын цол зэрэг:

Хураамж:

Оролцох ангилал:

Recreational level

Advanced level

Team level

Double level